БАТЛАВ
"ГАШУУН СУХАЙТ АВТО ЗАМ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ (З АМАРСАНАА)

2025 оны 05 дүгээр сарын 19.

АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

1.Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага:

1.1.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь Тохирлын үнэлгээ. Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага MNS ISO/IEC 17020 стандартын итгэмжлэлтэй төрийн болон хувийн хэвшлийн хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн байгууллага байна.

1.2. Хэмжил зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар шалгалт тохируулгад, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт зааснаар шалгалт баталгаажуулалтад хуваарийн дагуу тогтмол хамрагддаг хэмжилт, сорьц цуглуулалтын багаж, хэрэгсэлтэй байна.

1.3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, үнэлгээний арга зүйг эзэмшсэн, ажил мэргэжилтэй холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэлтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр нөлөөг үнэлэх чадамжтай орон тооны хөдөлмөрийн эрүүл ахуйн төрөлжсөн мэргэшил эзэмшсэн мэргэжилтэнтэй байна.

1.4. Үнэлгээний багийн мэргэжилтнүүд нь хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийсэн ажлын туршлагатай байна.

1.5. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний багийг ахалж ажиллах хөдөлмөрийн эрүүл ахуйч нь мэргэжлийн чадамжаа хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн холбоогоор баталгаажуулсан, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.

1.6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025" стандартаар итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг ашиглана.

1.7. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5080:2023 стандартын 4.3.9 дэх заалтын дагуу хэрэгжүүлэх боломжтой байна.

2. Хамрах хүрээ, хугацаа:

2.1. "Гашуун сухайт авто зам" ХХК-ийн ажилчдыг хамруулна. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдах ажлын байр, хийгдэх хэмжилтийн төрөл, тоо хэмжээг хавсралтад харуулав.

2.2. Хүйтний болон дулааны улиралд хэмжилт, үнэлгээг хийнэ.

3. Хийгдэх ажлууд:

3.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн өртөлтийг тодорхойлох

3.1.1. Физик хүчин зүйлс- агаарын температур, агаарын харьцангуй чийглэг, гэрэлтүүлэг, шуугиан /шуугианы түвшин хэмжигч хувь хүний доземетрээр/, доргион /бүх биед дамжих, гар дамжих/, агаарын даралт, цахилгаан соронзон орон, радио давтамж, дулааны цацраг, ионжуулагч цацрагийг хэмжих.

3.1.2. Химийн хүчин зүйлс- нийт болон нарийн ширхэгт тоос, цахиурын давхар исэл, хүнд металлын найрлага, ажлын байрны агаар дахь уур, хий байдалтай химийн бодисуудын нарийвчилсан хэмжилт хийж үнэлэх.

3.1.3. Эргономикийн хүчин зүйлс- эрсдэлийг илрүүлэх, үнэлэх.

3.1.4. Хөдөлмөрийн физиологийн хэмжилт- цусны даралт хэмжих, пульс тоолох, асуумж судалгаа, ажил мэргэжилтэй холбоотой ядралтын 15 зэрэг тодорхойлох, ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт өвчлөлийн судалгаа хийх, дүгнэлт гаргах.

3.2. Ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх

3.2.1. Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн өртөлтийг үнэлэн үр дүнг стандарт хэмжээтэй харьцуулан хэвийн бус ажлын байрыг тодорхойлох.

3.2.2. Үнэлгээ хийсэн ажлын байруудыг ижил өртөлтийн бүлгээр ангилах.

3.2.3. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дүгнэлт гаргах.

3.2.4. Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн өртөлт, нөлөөллийг бууруулах тохиромжтой хувилбарыг санал болгох.

3.3. Ажлын байранд хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх

3.3.1. Ажлын байрны үнэлгээ хийж ангилсан ижил өртөлтийн бүлгийн мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн эрсдэлийг тодорхойлох.

3.3.2. Ажилчдын өвчлөл, эрүүл мэндийн байдал, урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд дата боловсруулалт хийх.

3.3.3. Ажлын байруудад хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг зөвлөх.

3.3.4. Ажлын байранд тавигдах эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг ижил өртөлтийн бүлэг тус бүрээр гаргах.

3.4. Нэгдсэн зөвлөмж, дүгнэлт

3.4.1. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний тайлан гаргах.

3.4.2. Эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх.

3.4.3. Эрсдэлийн менежментэд зориулсан зөвлөмж боловсруулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх болсон тохиолдолд тохиромжтой хувилбарыг санал болгох.

3.5. Амьсгал хамгаалах хэрэгслийн тохирооны сорил хийх.

Үе шатны ажлын хуваарь

- Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана. Тухайн ажлыг 2 (хоёр) үе шаттай хийж гүйцэтгэнэ.

- Хүйтний улиралд (10- 2 сарын хооронд)
- Дулааны улиралд (05-09 сарын хооронд)

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх ажлын байрны жагсаалт

№	Алба хэлтэс	Ажлын байр/албан тушаал	Ажилтны тоо	Байршил
1	ЗТХЗА	Шалган нэвтрүүлэх цэгийн ажилтан	22	ШНЦ-1,ШНЦ-3,ШНЦ-4
2	ЗТХЗА	Хөдөлгөөн зохицуулалтын ажилтан	9	ШНЦ-1,ШНЦ-3,ШНЦ-4
3	ЗТХЗА	Хөдөлгөөнт эргүүлийн ажилтан	9	Цогтцэций, Цагаанхад
4	ЗТХЗА	Мэдээлэл шуурхай зохицуулалтын ажилтан	4	Цагаанхад
5	ЗТХЗА	Ээлжийн ахлах ажилтан	2	Цагаанхад
6	ЗЗАЭА	Замчин	9	Цогтцэций, Цагаанхад
7	ЗЗАЭА	Замын инженер	3	
8	ХАБЭА	ХАБ,Эмч	3	Цагаанхад
9	ТЗҮА	Механик инженер	1	
10	ТЗҮА	Засварчин жолооч	2	
11	ТЗҮА	Үйлчилгээний жолооч	7	
12	ТЗҮА	Аж ахуйн ажилтан	2	
13	ТЗҮА	Цахилгааны инженер	1	
14	ТЗҮА	Цахилгаанчин	2	
15	Санхүү	Нярав	1	
16	ТЗҮА	Харуул	2	Цагаанхад
17	ТЗҮА	Мэдээлэл технологийн инженер	2	

Бүтцэд хамаарах бусад алба хэлтсийн нийт ажилтан.

БОЛОВСРУУЛСАН:
ХАБЭА АХЛАХ АЖИЛТАН О.НАНДИНБААТАР

ХЯНАСАН:
ОРОН НУТАГ ДАХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН АХЛАХ МЕНЕЖЕР Б.ТҮВШИНЖАРГАЛ